



**МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ**



2014

ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

Монголын хөрөнгийн биржийн эрхэм зорилго

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

2014 оны эдийн засгийн үзүүлэлтүүд

Компани 2014 онд

Зах зээлийн тухай мэдээ, мэдээлэл

Олон улсын зах зээлийн тойм

Зах зээлийн бүтэц

Арилжаа, үнэт цаасны мэдээлэл

(Хувьцаа, Засгийн газрын үнэт цаас)

Иргэд, хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл

Цэнхэр, ягаан тасалбар

Тавантолгойн 1072 хувьцаа

Үнэт цаас гаргагчдад зориулсан мэдээлэл

Хувьцаа гаргах аж ахуйн нэгжид зориулсан мэдээлэл

Компанийн бонд гаргах аж ахуйн нэгжид зориулсан мэдээлэл

Байгууллагын танилцуулга

Компанийн засаглал

Бүтэц, зохион байгуулалт

Хүний нөөц

Цалин урамшуулал

МХБ-ийн сургалт

Бүртгэлтэй хувьцаат компани

Бүртгэлтэй хувьцаат компанийн бүтэц

Бүртгэлтэй ХК-уудын жагсаалт

Гишүүн үнэт цаасны компани

Гишүүн үнэт цаасны компанийн тухай

Гишүүн үнэт цаасны компанийн мэдээлэл

Санхүүгийн тайлан

Санхүүгийн байдлын тайлан

Орлогын тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖИЙН ХӨГЖЛИЙН
АЛСЫН ХАРАА**

Бүс нутгийн санхүүгийн төв - нээлттэй,
төрөлжсөн, хөрвөх чадвар сайтай зах
зээл болоход чиглэгдэнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, хамтран ажиллагч байгууллагууд, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч Та бүхэндээ Монголын хөрөнгийн биржийн 2014 оны тайланг танилцуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн 2014 онд Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд олон чухал ололт амжилтуудыг авчирсан жил болж өнгөрлөө. 3 жилийн туршид завсарлаад байсан Засгийн газрын үнэт цаас дахин Монголын хөрөнгийн биржээр дамжин арилжигдаж эхэлсэн бөгөөд нийт 60.4 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжиж, оны эцэст Монголын хөрөнгийн биржийн өдрийн дундаж гүйлгээ 1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт зах зээлийн үнэлгээ 1.4 их

наяд төгрөг болж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин 9.7 хувьд хүрлээ.

2014 онд Мерекс компани 65 сая ширхэг хувьцааг 2.6 тэрбум төгрөгөөр, БиДиСек хувьцаат компани 2.5 сая ширхэг хувьцааг 4.9 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд амжилттай арилжиж, хөрөнгийн зах зээлээс 7.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан төвлөрүүлсэн байна.

Лондонгийн хөрөнгийн бирж групптэй байгуулсан стратегийн түншлэлийн гэрээг Монгол улсын төсвөөс санхүүжилт гаргахгүй нөхцөлтэйгөөр дахин



гурван жилээр сунгаснаар санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үүсмэл санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг Лондон болон бусад олон улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх нөхцөл бүрдлээ.

Монголын хөрөнгийн бирж нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан тул Авлигатай тэмцэх газрын “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА” өргөмжлөл хүртсэн амжилтаар 2015 оныг угтсан.

Манай хамт олон үнэт цаасны арилжааг дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу шударга, нээлттэй, ил тод, зохион байгуулах, олон улсын туршлагаас суралцах, мэдээллийн ил тод байдлыг хангах зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийг төлөвшүүлэх замаар Монгол орныхоо эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилгыг өмнө тавьж ажиллаж байна.

Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болон үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид Та бүхэндээ ажлын амжилт хүсэж, сайн сайхныг хүсэн ерөөе!

Д.АНГАР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

2014 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15472.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 7.8 хувиар өслөө.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

хангасан байна.

ДНБ, оны үнээр 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 21844.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 14.3 хувиар өслөө.

Үүнд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 14.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбарынх 16.1 хувь, үйлчилгээний салбарынх 4.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ-ий 7.8 хувийн өсөлтийн 4.9 пунктийг уул уурхай, олборлох салбар, 1.7 пунктийг хөдөө аж ахуйн салбар, 1.6 пунктийг үйлчилгээний бусад салбар

УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны 1 дүгээр сард 353.6 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 366.4 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 12.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 46.5 тэрбумаар буурахад орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 11.3 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 17.3 тэрбум төг буюу 5.8 хувиар өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 36.5 тэрбум төг буюу 36.4 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 10.4 тэрбум төг буюу 41.6 хувь, онцгой албан татварын орлого 3.4 тэрбум төг буюу 10.3 хувь, орлогын албан татварын орлого 3.1 тэрбум төг буюу 5.9 хувиар буурсан хэдий ч бусад татвар төлбөр хураамжийн орлого 62.3 тэрбум төг буюу 3.6 дахин,

нийгмийн даатгалын орлого 8.0 тэрбум төг буюу 12.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 89.9 хувийг татварын орлого, 10.1 хувийг татварын бус орлого эзэлж өмнөх оны мөн үеийнхээс татварын бус орлогынх 4.9 пунктээр буурч, татварын орлогынх 4.9 пунктээр өсжээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны 1 дүгээр сарын эцэст 10.3 их наяд төг болж, өмнөх сарынхаас 311.3 тэрбум төг буюу 2.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс тэрбум төг буюу 3.0 хувиар өсөхөд нийт хадгаламж өмнөх сарынхаас 180.2 тэрбум төг, өмнөх оны мөн үеийнхээс 688.5 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2015 оны 1 дүгээр сарын эцэст 732.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 77.3 тэрбум төг буюу 9.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 161.9 тэрбум төг буюу 18.1 хувиар буурчээ.

Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2015 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 490.5 тэрбум төг буюу 18.7 хувиар буурч, 2129.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт

(сарын эцэст, тэрбум төг)


Үзүүлэлт	2014		
	X	XI	XII
Мөнгөний нийлүүлэлт M2	10021.9	10635.8	10324.5
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе = 100	36.5	12.5	3.0
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар = 100	7.6	7.7	-2.9
Нийт хадгаламж	6 871.8	7 380.1	7 560.3
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе = 100	37.7	10.2	8.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар = 100	1.1	8.7	-0.8
Валютын хадгаламж	1 907.5	1 969.8	2 195.8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе = 100	43.2	33.4	15.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар = 100	29.2	5.0	11.5

ИНФЛЯЦИ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2014 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, оны эхнээс 11.0 хувиар өслөө. Ерөнхий индекс 2014 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, бөс бараа, гутлын бүлгийнх 1.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ГАДААД ХУДАЛДАА

Монгол улс 2014 онд дэлхийн 139 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

нийт бараа эргэлт 11.0 тэрбум ам.долл, импорт 5.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. 2014 онд 2013 оныхоос нийт бараа эргэлт 384.3 сая.долл буюу 3.6 хувь, экспортын хэмжээ 1505.5 сая ам.доллар буюу 35.3 хувиар өсч, харин импортын хэмжээ 1.1 тэрбум ам.доллар буюу 17.6 хувиар буурчээ. Гадаад худалдааны тэнцэл 2013 онд 2.1 тэрбум ам.долларын алдагдалтай



гарч байсан бол 2014 онд 537.9 сая ам.долларын ашигтай гарлаа.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 89.8 сая ам.доллар буюу 26.6 хувиар буурахад машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт 26.6 сая ам.доллар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийнх 14.4 сая ам доллар, хүнсний бүтээгдэхүүнийх 11.3 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 89.3 хувийг эзэлж байгаа бол импортын 56.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2014 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 153 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 27 тэрбум төгрөгөөр буюу нийт 21,4 хувиар өссөн байна.



Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт 2014 онд анх удаа 40.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс энэ хэмжээгээр буурч одоогийн байдлаар 820.6 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 15.9 хувийг эзэлж байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2014 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 351 банк бус санхүүгийн байгууллагууд нь 490 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 146 тэрбум төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн байна. Мөн дээрх хугацаанд татварын дараах цэвэр ашиг 26.7 тэрбумд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5.7 тэрбум

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2014 оны жилийн эцсийн байдлаар 159 хадгаламж зээлийн хоршоо Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн дээрх тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 80.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9.5 тэрбум төгрөгөөр буюу 13.4 хувиар өсжээ.

КОМПАНИ 2014 ОНД



“МЕРЕКС” ХК ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД IPO ХИЙЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 514 тоот тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн бирж “Мерекс” (MSE:MRX) ХК-ий 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,005,000 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны жагсаалтад 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр бүртгэсэн.

2012 онд “Мерекс” ХК гадаад худалдаа, барилгын материалын худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан. Сонгинохайрхан дүүрэгт БНСУ-д үйлдвэрлэсэн, цагт 150 м.куб бетон үйлдвэрлэх хүчин чадалтай TW-2500 маркийн бетон зуурмагийн үйлдвэр барьж буй юм. Цаашид үйлдвэрлэлийг жигдрүүлж, бизнес төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж, компани үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхээр 2.6 тэрбум төгрөгийг зах зээлээс татан төвлөрүүлэх үйл ажиллагаа амжилттай явагдаж дууссан бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 2014 оны 4 дүгээр сарын 21-ий өдөр эхлэн арилжаа нь явагдаж байна.



САНГИЙН ЯАМ МХБ-ИЙН ХУВЬ ЭЗЭМШИГЧ БОЛЛОО



САНГИЙН ЯАМ

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн. Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн

удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Уул уурхай яам, Хөгжлийн банкны төлөөлөл орж ажиллаж байна.

“МХБ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР Д.АНГАРЫГ ТОМИЛЛОО



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 2014/04 тогтоолоор Д.Болормааг үүрэгт ажлаас чөлөөлж, Д.Ангарыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилсон.

Даваасүрэнгийн Ангар нь 1978 онд төрж, 1995 онд Нийслэлийн Физик математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 11 дүгээр дунд сургуулийг төгссөн. АНУ-ын Төв Арканзасын Их Сургуулийг Санхүүч мэргэжлээр бакалавр, Ливерпүүлийн Их Сургуулийг Олон улсын санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ШУ-ны магистрын зэрэгтэйгээр





төгссөн. 2002 онд Сангийн Яаманд мэргэжилтнээр ажилд орсноор ажлын гараагаа эхэлсэн. 2008 онд тус яамны Өрийн удирдлагын хэлтсийн даргаар томилогдон ажиллаж Засгийн газрын үнэт цаасны арилжаа, өрийн удирдлага, үйлчилгээ, эрсдэл зардлын шинжилгээ, Засгийн газрын зээл, төсөв мөнгөн хөрөнгийн удирдлага, хугацаа хэтэрсэн өрийн хэлэлцээ зэрэг асуудлуудыг хариуцан ажиллаж байсан. 2011-2014 онуудад Монгол Улсаас Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Элчин сайдын яаманд худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөхийн албан тушаалыг хашиж байжээ.

СТРАТЕГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ДАХИН 3 ЖИЛЭЭР СУНГАВ



London
Stock Exchange Group

Монголын Хөрөнгийн бирж нь 2011 онд Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж, олон улсын хөрөнгийн зах зээл дэх шилдэг стандарт, практикийг нэвтрүүлснээр Монголын хөрөнгийн биржийг дэлхийн хэмжээний бирж болгон хөгжүүлэх зорилт тавин ажилласан. 2014 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Лондон хотноо зохион байгуулагдсан “Монголын хөрөнгийн зах зээл” арга хэмжээний үеэр хоёр тал өмнө нь эхлүүлсэн стратегийн хамтын ажиллагааны гэрээг Монгол улсын





төсвөөс ямар нэг санхүүжилт гаргахгүй нөхцөлтэйгөөр дахин 3 жилээр сунгаж, стратегийн түншүүд гэдэг статусаа хадгалж, шинэчлэн батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн хүрээнд Монгол улсын хөрөнгийн зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үүсмэл санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг Лондон болон бусад олон улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдад Монголын зах зээлийг сурталчлах зэрэг асуудлуудыг гэрээнд тусгаж гарын үсэг зурлаа.

2013-2014 ОНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖИЙГ БУУРУУЛЖ, АРИЛЖААНЫ СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХИЙГ ҮНЭГҮЙ БОЛГОЛОО



Монголын хөрөнгийн бирж нь гишүүн брокер, дилерийн компаниудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос гаргасан санал, хүсэлтийг харгалзан гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээг бууруулах шийдвэр гарган ажиллаа. Гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээ 2.5-3.5 сая төгрөг байсныг 1.5 сая төгрөг болгон бууруулж, арилжааны системд нэвтрэх эрх буюу терминал ашиглах төлбөр (Нэг сарын 195,000 төгрөг, жилийн 2.3 сая төгрөг)-ийг 2014 оныг дуустал бүрэн чөлөөлөж ажиллаа. Ийнхүү хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлснээр нэг гишүүн компанид нийтдээ 8 орчим сая төгрөгийн хэмнэлт гарав.



ҮНЭТ ЦААСНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЛИЙГ МОБАЙЛ АППЛЕКЕЙШНААР ДАМЖУУЛАН ОЛОН НИЙТЭД ХҮРГЭДЭГ БОЛЛОО



Монголын хөрөнгийн бирж нь 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдөр арилжааны болон ханшийн мэдээллийг гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан мобайл апплейкешны тусламжтайгаар олон нийтэд хүргэх боломжтой боллоо. Тус программыг ашиглахын тулд App Store-д “MN Stocks” гэсэн апплейкешныг татан суулгах хэрэгтэй. Уг программыг ашигласнаар хэрэглэгч ханшийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэх боломжтой юм. Тус апплейкешн нэвтэрснээс хойш 2 сарын хугацаанд нийт 300 гаруй хэрэглэгчтэй болсон байна.

Тохиргоо		+
APU	АПУ ХК	
BAN	Багануур ХК	
BNG	Баянгол зочид буудал ХК	
BDS	Би ди сек ХК	
GOV	Говь ХК	
JTB	Женко тур бюро ХК	
BDL	Могойн гол ХК	
MSH	Монгол шилтгээн ХК	
MDP	Монгол шилтгээн ХК	

Ханш		i
APU	3,705.00	+5.00
BAN	3,700.00	0.00
BNG	60,000.00	0.00
BDS	2,499.00	0.00
GOV	8,000.00	0.00
JTB	88.00	0.00
BDL	10,000.00	0.00
MSH	649.96	0.00
MDP	570.00	0.00



3 ЖИЛИЙН ТУРШИД ЗАВСАРЛААД БАЙСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭ ЦААС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАХИН АРИЛЖИГДАЖ ЭХЭЛЛЭЭ



САНГИЙН ЯАМ

Сангийн яам (Үнэт цаас гаргагч) болон Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний 389 тоот тогтоолоор 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гаргасан.

Сангийн яамнаас ирүүлсэн нөхцөлийн дагуу олон нийтэд санал болгох жижиглэнгийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй ЗГҮЦ-ыг долоо хоног бүр МХБ-ээр арилжаалсан бөгөөд тус үнэт цаасны хүүгийн хэмжээ нь тухайн долоо хоногт Монгол банкинд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогдсон.

2014 онд 9 өдрийн арилжаагаар нийт 36.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Мөн 2015 онд Засгийн газрын зүгээс ийнхүү хөрөнгийн зах зээл, түүнд оролцогчдыг дэмжих зорилгоор эрсдэлгүй, татвараас чөлөөлөгдөх, богино хугацаат ЗГҮЦ-ыг хөрөнгийн биржийн арилжаагаар олон нийтэд чөлөөтэй анхдагч болон хоёрдогч зах зээлд үргэлжлүүлэн арилжих болно.





“MSE ALL” ИНДЕКСИЙГ ТООЦОЖ ЭХЭЛЛЭЭ

Mongolian Stock Exchange

MSE ALL
index

МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар шинэчлэн батлагдсан “Үнэт цаасны индекс тооцох тухай журам”-ыг СЗХ-ноос албан ёсоор батламжиллаа. 2015.02.09-ний өдрөөс “MSE ALL” (Нэгдсэн) индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд нэгдсэн индексийн сагсанд МХБ дээр бүртгэлтэй, үнэт цаас нь арилжигддаг нийт 212 компанийн үнэт цаас бүгд багтах юм. MSE ALL индекс 1,000 нэгжээс тооцогдож эхэлнэ. 2014 оны сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч 20 компаниас 16 компани хэвээр үлдэж, “Могойн гол” ХК, “Монгол шилтгээн” ХК, “Силикат” ХК, “Сүү” ХК зэрэг үнэт цаасууд хасагдаж, “УБ БҮК” ХК, “Гермес центр” ХК, “Материалимпекс” ХК, “Махимпекс” ХК зэрэг үнэт цаасууд шинээр нэмэгдсэн байна.

МХБ ТӨХК НЬ АВЛИГААС АНГИД САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА ӨРГӨМЖЛӨЛ ХҮРТЛЭЭ



Монголын Хөрөнгийн Бирж нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, ажилтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан тул 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧЛАГА” өргөмжлөл хүртлээ.

МХБ-ИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА



Монголын хөрөнгийн биржийн Бүртгэлийн журмын шинэчилсэн найруулгыг 2014 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсан. Энэхүү журмын шинэчилсэн найруулгаар гадаадад бүртгэлтэй хуулийн этгээд Монголын хөрөнгийн биржид үнэт цаас гаргах, монголд бүртгэлтэй компани гадаад улсад үнэт цаас гаргах буюу давхар бүртгэл, хувьцааны бүртгэлийн I, II, III гэсэн гурван ангилал, бүртгэлтэй компаниудын тогтмол биелүүлэх үүрэг буюу мэдээллийн ил тод байдлыг хангах, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх талаар нэмэлт асуудлуудыг зохицуулж өгсөн. Хувьцааны бүртгэлийн I ангилалд нэр хүндтэй, зах зээлийн үнэлгээ өндөртэй, тогтвортой үйл ажиллагаа явуулж, ашиг орлоготой ажилладаг компаниуд багтана. Харин II ангилалд нэг тэрбум төгрөгөөс дээш хэмжээний зах зээлийн үнэлгээтэй,



жилийн хугацаанд хэрэглэх эргэлтийн хөрөнгөтэй дунд зэргийн компаниуд бүртгэгдэх бол III ангилалд шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, жижиг дунд хэлбэрийн компаниуд эсхүл хайгуулын ашиглалтын лиценз бүхий уул уурхайн компаниудын хувьцааг бүртгэн арилжих боломжтой болсон байна.

МХБ-ИЙН “ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ” БОЛОН “ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ” ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 08 сарын 13-ны өдрийн хурлаар батлагдсан “Хяналт шалгалтын журам” болон “Гишүүнчлэлийн журам”-ыг 2014 оны 10 сарын 03-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо батламжилснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ

МХБ-д шинээр гишүүн элсэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах болон гишүүний үйл ажиллагаатай холбоотой бусад харилцаа нь “Гишүүнчлэлийн журам”-аар, харин биржийн үнэт цаасны арилжааны хяналт шалгалт болон гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд тавих хяналттай холбоотой үүсэх харилцаа нь “Хяналт шалгалтын журам”-аар зохицуулагдах болно.

Ийнхүү Санхүүгийн зохицуулах хороо дээрх хоёр журмыг батламжилснаар Монголын хөрөнгийн биржээс “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-тай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай үндсэн зохицуулалтууд хийгдэж дууслаа.

ХЭМНЭЛТИЙН ГОРИМД ШИЛЖИН АЖИЛЛАВ

Санхүүгийн хүнд нөхцөл байдлаас шалтгаалан Монголын хөрөнгийн бирж 2014 оны 8 дугаар 4-ний өдрөөс эхлэн хэмнэлтийн горимд шилжин ажилласан. Үүний хүрээнд байгууллагын дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, Тэргүүн дэд захирал, дэд захирал болон тэдгээрт үйлчлэх жолоочийн болон ажлын байрны тодорхойлолтод тэнцэхгүй шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн бусад орон тоог хэмнэх, томоохон худалдан авалтыг зогсоох, бүх төвшинд зардал хэмнэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг сайжруулсны үр дүнд нийт зардлын гүйцэтгэлийг 23 хувиар бууруулж чадсан ба нийт ажилтнууд болон ТУЗ-ийн гишүүд өөрсдийн санаачилгаар цалингаа 30 хувиар бууруулах шийдвэрийг гаргасан юм. Үүний үр дүнд Монголын хөрөнгийн биржийн санхүүгийн нөхцөл байдал сайжирч, улмаар 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс санхүүгийн хэвийн горимд шилжих нөхцөл бүрдсэн юм.

2014 оны эцсийн байдлаар дотоодын болон гадаадын аливаа аж ахуйн нэгжид хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байна.



ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕРИЙН ТУХАЙ

“Итгэмжлэгдсэн дилер” буюу “Market Makers” нь олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц бөгөөд үнэт цаасны арилжааг идвэхжүүлж, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, үнэт цаасны ханшын огцом хэлбэлзэлээс сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой байдаг.

Монголын хөрөнгийн биржийн гишүүн ҮЦК-иуд дилерийн үйл ажиллагаа явуулах нь хомс, ихэнхдээ зөвхөн хөрөнгө оруулагчдын захиалгаар биржийн арилжаанд оролцож байсан нь арилжааны дүн бага, үнэт цаасны хөрвөх чадвар муу байх хүчин зүйлийн нэг болж байв.

Иймд Монголын хөрөнгийн биржийн зүгээс эхлээд Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог нэвтрүүлж, цаашдаа компанийн бонд, хувьцаа болон үүсмэл үнэт цааснуудын арилжаанд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжүүлж эхэлсэн.

Ингэснээр “Итгэмжлэгдсэн дилер” үнэт цаасны компаниуд нь Монголын хөрөнгийн биржийн арилжааны өдөр бүр Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн худалдах, худалдан авах үнийн саналыг давхар гаргах бөгөөд энэ нь үнэт цаасны арилжааг идэвхжүүлж, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагч нь хүссэн өдрөө Засгийн газрын үнэт цаас худалдан авах эсвэл эргүүлэн зарах боломжийг бүрдүүлэх юм.





2014 ОНД БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕС, ГАДААД ХАРИЛЦАА

Монголын хөрөнгийн бирж нь өөрийн стратеги түнш болох Лондонгийн хөрөнгийн бирж групп болон бусад гадны байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр ирлээ.

FTSE компанийн "Ажиглалтын" жагсаалтад хэвээр үлдэв

FTSE компани нь 80 гаруй улсын хөрөнгийн зах зээлийн 200,000 гаруй индексийг арилжааны төгсгөлд болон бодит цагийн горимоор тооцоолон гаргаж зах зээлд мэдээлдэг компани юм. FTSE компани нь тухайн орны зах зээлийг Developed, Advanced Emerging, Secondary Emerging болон Frontier гэсэн хэсгүүдэд хувиарлан авч үздэг. Харин манай зах зээлийн хувьд, Frontier жагсаалтад орох бололцоотой гэж FTSE үзээд өөрийн ажиглалтын жагсаалтанд Монголын хөрөнгийн зах зээлийг багтаагаад байсан билээ. FTSE нь дээрх жагсаалтуудыг жил бүрийн 9 сард авч үздэг бөгөөд 2014 оны хувьд манай зах зээлийг ажиглалтын жагсаалтандаа хэвээр үлдээсэн.


FTSE индекс



Монголын хөрөнгийн бирж нь 2013 оны 8 дугаар сарын 21-ний өдөр FTSE компанитай хамтран санхүүгийн индекс тооцоолох хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд FTSE MSE All-liquid, FTSE MSE Board A болон FTSE MSE Top 20 зэрэг индексүүдийг хамтран тооцоолж гаргахаар болсон. Монголын хөрөнгийн бирж нь эдгээр индексүүдийн суурийг тавих зорилгоор MSE All индексийг нэвтрүүлээ.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

АЗИЙН ЗАХ ЗЭЭЛ 2014 ОНД




Ази тивийн голлох эдийн засаг - Хятадын эдийн засгийн үзүүлэлтээс Ази тивийн бусад орны эдийн засаг ихээхэн нөлөөлдөг. 2014 онд Хятад Улс 7.4 хувийн өсөлттэй гарч өмнөх оноос 0.3 хувиар буурсан боловч БНХАУ-ын Ардын банкнаас зээлийн болон хадгаламжийн хүүг бууруулснаар хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах хандлага нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ унасан нь үйлдвэрлэгч орны хувьд Хятад таатай нөхцөлийг бүрдүүлж (SSE) индекс болон нийт зах зээлийн үнэлгээ өсөхөд ихээхэн нөлөөлжээ. Японы төв банкны мөнгөний бодлогыг сулруулахыг хүлээж оны эхнээс 4 сар дараалан унаад байсан (NIKKEI 225) индекс 5 сараас эхлэн өссөөр оны эцэст 9.7 хувиар өссөнд 10 сараас иений ханш суларч экспортлогчдод таатай нөхцөл бүрдсэн нь нөлөөлжээ.

Солонгосын хувьцааны үнийн нэгдсэн индекс буюу (KOSPI) нь шинэ засгийн газрын "эдийн засгийг дэмжих төлөвлөгөө" болон хүүгийн хэмжээ бууруулах бодлогыг дагаад 7 сарын эцэс хүртэл сүүлийн гурван жилийн хамгийн өндөр үзүүлэлтэнд хүрээд байсан бол нийт зах зээлийн үнэлгээний 14.4 орчим хувийг эзлэгч "Samsung"-ийн хувьцааны уналт 7 сарын эцсээс эхлэн сүүлийн 2 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн нь индекс буурахад голлох нөлөөг үзүүлжээ.



ЕВРОПЫН ЗАХ ЗЭЭЛ 2014 ОНД




Европын зах зээл 2014 онд багагүй хэлбэлзэлтэй байлаа. Жилийн дунд үед буюу 7 дугаар сарын эхэнд голлох гурван индекс нь оны эхэнтэй харьцуулахад бага зэргийн өсөлттэй байсан бол оны эцэст харилцан адилгүй өсөлттэй гарсан юм. 2014 оны 10 дугаар сард дээрх индексүүд уналттай байсан нь Грек улсыг европын холбооноос гаргах тухай саналууд гарч, зах зээл дахин хямрах магадлалтай гэсэн хөрөнгө оруулагчдын болгоомжлолыг тусгасан явдал байлаа.

2014 онд FTSE 100 индекс нь (Их Британи) 6650 нэгж, CAC 40 индекс нь (Франц) 4250 нэгж орчимд хэлбэлзэж байсан бөгөөд энэ нь эдгээр индексүүдийн 2008 оны хямралын өмнөх үеийн төвшинд хүрсэн үзүүлэлт байлаа. Харин Германы индексийн (DAX) хувьд 2014 оны байдлаар өмнө нь хүрч байгаагүй түвшинд гарсан жил байлаа.

Европын зах зээл өнгөрөгч оны эхний хагаст багагүй идэвхижсэн. Тухайлбал, шинээр хөрөнгийн бирж дээр гарах компанийн тоо эрс нэмэгдсэн бөгөөд оны эхний 11 сарын байдлаар татсан хөрөнгийн хэмжээ өмнөх 2 жилийн нийт дүнгээс ч их гарсан юм. Харин 2014 оны хоёрдугаар хагаст Украин болон Ойрхи Дорнод дахь геополитикийн тогтвортой бус байдал, Хятад болон Европын эдийн засгийн тодорхой бус хөгжлийн чиг хандлага зэрэг аж байдал тус бүс нутгийн зах зээлд багагүй нөлөө үзүүлэв.

АМЕРИКИЙН ЗАХ ЗЭЭЛ 2014 ОНД



2014 онд Хойд Америкийн голлох биржүүдийн индекс болон тэдгээрийн зах зээлийн үнэлгээ нь өссөн үзүүлэлттэй гарсан нь тус бүс нутгийн эдийн засгийн өсөлттэй салшгүй холбоотой юм. АНУ-ын хувьд гэвэл занарын боловсруулалтаас гарч буй газрын тосны үйлдвэрлэл өмнөх жилүүдээс өсч мөн хямд газрын тосны нөлөөнд эдийн засагт худалдан авалт нэмэгдсэн байна. Мөн ам.долларын бусад валюттай харьцуулсан ханш чангарч, 4-5 жил уналттай байсан үл хөдлөх хөрөнгийн салбар дахин сэргэж эхэлсэн ба жижиг дунд бизнесүүд хүчээ авч, ажилгүйдэл буурсан, гадаад худалдаан тэнцэл нь өмнөх жилүүдтэй харьцуулахад ашигтай гарсан зэрэг олон эерэг хүчин зүйлүүдээс шалтгаалж АНУ-ын эдийн засаг өсөлт 2014 онд 2.4 хувьд хүрэв.

2014 оны 4 дүгээр улиралд Хойд Америкт үндэсний томоохон баяр болдог бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэдийн худалдан авалт огцом нэмэгдсэн нь худалдааны салбарын компаниудын ашгийн хэмжээг өсгөхөд нөлөөлж голлох биржүүдийн индекс 5%-р өссөн байна. Мөн Apple, Google зэрэг мэдээлэл технологийн компаниудын тайлант хугацааны цэвэр ашгийн хэмжээ өндөр гарсан нь зах зээл эерэг нөлөө үзүүлсэн байна. Харин Торонтогийн хөрөнгийн биржид дэлхийн томоохон уул уурхайн компаниуд бүртгэлтэй байдаг бөгөөд металл түүхий эдийн үнийн уналтын улмаас тус биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны ханш буурч сүүлийн хагас жилд зах зээлийн үнэлгээ 0.2% буусан байна.




ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Үнэт цаасны зах зээлийн үндсэн бүтэц нь - Зохицуулагч байгууллага, - Арилжаа эрхлэгч, байгууллага, - Хадгаламжийн байгууллага, - Төлбөр тооцооны байгууллага, - Зуучлагч байгууллага, - Хөрөнгө оруулагчид, - Үнэт цаас гаргагчид-аас бүрддэг.

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 100 хувь төрийн өмчийн компани тул Төрийн өмчийн хорооны харъяанд байсныг Монгол Улсын Засгийн газар 2014 оны тавдугаар сарын 10-нд “Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 тоот тогтоол гаргаж, Монголын хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн.


- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны арилжаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагддаг байсныг 2012 оны 12 дугаар сараас эхлэн Монголбанкар дамжуулан арилжаалах болсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний 389 тоот тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасыг эргүүлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан.



АРИЛЖАА, ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 255 удаагийн арилжаагаар 137 компанийн 51.7 сая ширхэг хувьцааг 24.2 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны 9 удаагийн арилжаагаар 375.5 мянган ширхэг үнэт цаасыг 36.1 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 60.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.



Нийт гүйлгээний үнийн дүнгийн 40.16% буюу 24.2 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 59.84% буюу 36.1 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

БАГЦЫН АРИЛЖАА



Тайлант хугацаанд багцын арилжаагаар нийт 20.1 сая ширхэг хувьцааг 12.8 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 52.95 хувийг эзэлж байна.

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон гаргасан “Мерекс” компанийн 9.6 сая ширхэг хувьцааг 965.9 сая төгрөгөөр, “БиДиСек” ХК-ийн 520.7 мянган ширхэг хувьцааг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд арилжсан байна. Анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 10.2 сая ширхэг хувьцааг 2.08 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны 8.59 хувийг эзэлж байна.



ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт 62 брокер дилерийн компани бүртгэлтэй байгаа бөгөөд 2014 онд 52 компани үнэт цаасны арилжаанд оролцож гүйлгээ хийсэн байна.

Үнэт цаасны БиДиСек, Ти Ди Би Капитал, Тулгат чандмань баян, Тэнгэр капитал, Голомт секюритиз, Дэлгэрхангай секюритиз, Стандарт инвестмент зэрэг компаниуд тэргүүлсэн байна.

ХАМГИЙН ИХ ГҮЙЛГЭЭ ХИЙСЭН 20 ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙГ ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛАВ

Д/д	ҮЦК-ийн код	Үнэт цаасны компанийн нэр	Нийт тоо ширхэг	Нийт үнийн дүн
1	BDSC	"БиДиСек ҮЦК" ХК	66,028,413	27,135,989,325
2	TDB	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	458,786	16,823,749,257
3	TCHB	"Тулгат чандмань баян ҮЦК" ХХК	492,720	6,564,184,831
4	TNGR	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	1,326,716	5,652,887,729
5	GLMT	"Голомт секюритиз ҮЦК" ХХК	256,343	5,469,429,556
6	DELG	"Дэлгэрхангай секюритиз ҮЦК" ХХК	4,065,090	3,453,245,358
7	STIN	"Стандарт инвестмент ҮЦК" ХХК	19,313,884	2,948,618,819
8	MSEC	"Монсек ҮЦК" ХХК	4,557,487	2,868,839,066
9	GNDX	"Гендекс ҮЦК" ХХК	576,401	2,256,995,180
10	APS	"Азиа Пасифик секьюритис ҮЦК" ХХК	813,768	1,917,355,647
11	ARGB	"Аргай бэст ҮЦК" ХХК	123,059	1,332,682,210
12	MIBG	"Эм Ай Би Жи ҮЦК" ХХК	42,981	821,727,853
13	BZIN	"Дэү Секьюритис ҮЦК" Монгол	24,508	763,161,689
14	BULG	"Булган брокер ҮЦК" ХХК	207,632	748,032,930
15	ECM	"Евразиа капитал монголиа ҮЦК" ХХК	1,177,860	722,864,405
16	ALTN	"Алтан хоромсог ҮЦК" ХХК	53,351	676,512,094
17	GATR	"Гацуурт трейд ҮЦК" ХХК	68,129	588,627,603
18	NSEC	"Нэйшнл сэкьюритис ҮЦК" ХХК	844,592	456,584,323
19	DRBR	"Дархан брокер ҮЦК" ХХК	605,253	430,525,775
20	ARD	"Ард капитал групп ҮЦК" ХХК	316,690	426,384,720
Нийт			101,353,663	82,058,398,371
Нийт арилжаанд эзлэх хувь			97.63	96.99



2014 ОНД ХИЙГДСЭН АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 86.9 сая төгрөгийн гүйлгээ хийж, 162.9 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.



ТОП-20 ИНДЕКС

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 17160.49 нэгж, доод үзүүлэлт 14475.20 нэгж, дундаж үзүүлэлт 15744.98 нэгж байлаа.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1447.57 нэгжээр буюу 8.88 хувиар буурч, 14854.24 нэгж болсон байна.





ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоолын дагуу нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1,000,000 ширхэг буюу 100.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны жагсаалтанд бүртгэж, 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн олон нийтэд арилжиж эхлээд байна.

Тайлант хугацаанд 9 удаа Засгийн газрын үнэт цаасны арилжаа явагдаж, 12, 28, 52 долоо хоногийн хугацаатай нийт 375.5 мянган ширхэг үнэт цаасыг 36.1 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа (7 хоног)	Зарагдсан тоо хэмжээ (ш)	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн (төгрөг)
2014.11.04	ЗГЭБ-Б-12-274	12	45,020	15.795%	4,344,114,860.00
2014.11.11	ЗГЭБ-Б-52-275	52	2,304	16.25%	230,400,000.00
2014.11.18	ЗГЭБ-Б-12-276	12	55,337	15.99%	5,337,308,987.00
2014.11.25	ЗГЭБ-Б-28-277	28	24,961	16.3%	2,295,213,872.00
2014.12.02	ЗГЭБ-Б-12-278	12	26,816	15.96%	2,586,590,912.00
2014.12.09	ЗГЭБ-Б-52-279	52	2,057	16.625%	205,700,000.00
2014.12.16	ЗГЭБ-Б-12-280	12	152,978	15.731%	14,763,294,868.00
2014.12.23	ЗГЭБ-Б-28-281	28	4,888	16.436%	449,158,320.00
2014.12.30	ЗГЭБ-Б-12-282	12	61,178	15.653%	5,905,084,094.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ			375,539		36,113,993,535

ЗГЖҮЦ нь хувь хүн, аж ахуйн нэгжид зориулсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд нэгж бүр нь 100,000.0 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтсон хугацаанд хүү төлдөг (тогтмол хугацаанд эсхүл үнэт цаасны хугацааны эцэст) Засгийн газрын өрийн бичиг юм.

ЗГЖҮЦ-ыг худалдан авах нь дараах давуу талуудтай байна. Үүнд:

- Засгийн газрын аливаа өрийн бичиг, үнэт цаас нь хамгийн эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог.



- б. Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 16.1.16, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.1-д тус тус зааснаар Засгийн газрын үнэт цаасны төлбөр, хүү нь татвараас чөлөөлөгдөх орлогод тооцогддог.
- в. Засгийн газрын үнэт цаасны хүү, өгөөж нь зах зээлийн зарчмаар тогтоогддог тул зах зээлийн нөхцөл байдалтай уялдаж өндөр өгөөжтэй байдаг.
- г. Засгийн газрын үнэт цаас нь хөрвөх чадвартай байдаг буюу үнэт цаасыг хугацаа нь дуусахаас өмнө аливаа торгуульгүйгээр бусад этгээдэд худалдах, бэлэглэх, барьцаалах бүрэн боломжтой.


Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.7, 5.1.8, 5.1.17, 20.2, 43.7-д тус тус заасны дагуу Засгийн газрын үнэт цаасыг тендерийн, урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгаа болгох боломжтой.

ЗГЖҮЦ-НЫ ХҮҮГИЙН ТҮВШИН

ЗГЖҮЦ-ны хүүгийн түвшин, үнийг зах зээлийн жишигт нийцүүлэн Сангийн яамнаас тогтооно. ЗГЖҮЦ-ны арилжааг долоо хоног бүр зохион байгуулах бөгөөд долоо хоног бүрийн Лхагва гарагийн 14:00 цагт санал авах хугацааг эхлүүлж, энэ нь дараа долоо хоногийн Мягмар гарагийн 11:00 цаг хүртэл үргэлжилнэ. Сангийн яамнаас тогтоосон хүү нь энэхүү санал авах хугацааны турш хүчинтэй байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 227.87 тэрбум төгрөгөөр буюу 13.64 хувиар буурч, 1 их наяд 442.6 тэрбум төгрөг болсон байна.



**ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ**

Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ (Тэрбум төг)
АПУ	278.88
ТАВАН ТОЛГОЙ	231.52
БЭРХ УУЛ	68.22
ШИВЭЭ ОВОО	67.10
ШАРЫН ГОЛ	61.75
БАГАНУУР	60.80
ГОВЬ	58.12
УБ БҮК	48.34
СҮҮ	41.28
МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	39.66
БИДИСЕК	38.76
МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	33.63
БАЯНГОЛ ЗБ	24.54
МАТЕРИАЛИМПЕКС	21.89
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	21.50
ДАРХАН НЭХИЙ	19.36
ТАЛХ ЧИХЭР	18.95
ГУТАЛ	15.38
МАХИМПЕКС	14.06
ГЕРМЕС ЦЕНТР	13.35
ТАХЬ КО	13.09
АТАР ӨРГӨӨ	11.84
СИЛИКАТ	10.43
АРИГ ГАЛ	9.77
ХӨХ ГАН	9.63
АВТОИМПЕКС	9.25
ЖЕНКО ТУР БЮРО	9.00
АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС	8.71
МОГОЙН ГОЛ	8.21
РЕМИКОН	7.79
НИЙТ	1,274.80
НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ	88.36



ИДЭВХТЭЙ АРИЛЖАГДСАН 30 ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААС	АРИЛЖИГДСАН ШИРХЭГ	Эрэмбэ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
СИЛИКАТ	15,999,090	1	СИЛИКАТ	3,601,713,286
МЕРЕКС	9,922,958	2	БАЯНГОЛ ЗБ	3,247,042,200
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	6,938,282	3	МОНИТ БУЛИГААР	2,285,687,830
ЖЕНКО ТУР БЮРО	4,398,445	4	МОНГОЛ ШИЛТГЭЭН	1,867,490,848
МОНГОЛ ШИЛТГЭЭН	3,343,922	5	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	1,377,492,493
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	2,600,965	6	БИДИСЕК	1,164,273,369
РЕМИКОН	1,651,751	7	МЕРЕКС	992,853,018
МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	1,305,488	8	АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС	887,725,210
ГЕРМЕС ЦЕНТР	837,401	9	ДАРХАН НЭХИЙ	835,889,460
БИДИСЕК	540,232	10	МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	788,835,108
ХАЙ БИ ОЙЛ	531,333	11	АПУ	720,112,356
ХӨХ ГАН	453,854	12	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	700,538,583
БИНСЭ ХК	374,803	13	ТАВАН ТОЛГОЙ	559,916,930
АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС	359,393	14	ЖЕНКО ТУР БЮРО	392,185,595
МОНИТ БУЛИГААР	318,655	15	ШАРЫН ГОЛ	384,630,270
СОР	206,557	16	ГОВЬ	380,404,300
АПУ	189,096	17	СОР	364,916,599
ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	146,440	18	МОНГОЛ НЭХМЭЛ	338,676,617
МОНИНЖБАР	133,513	19	РЕМИКОН	247,751,374
ОЛЛОО	127,253	20	ХАЙ БИ ОЙЛ	211,434,374
ТАВАН ТОЛГОЙ	111,647	21	БИНСЭ ХК	207,798,879
ГОВИЙН ӨНДӨР	91,250	22	УБ БҮК	193,824,760
БАЯНБОГД	88,027	23	СҮҮ	170,630,540
ХӨНГӨН БЕТОН	77,148	24	МАТЕРИАЛИМПЕКС	163,014,960
МОНГОЛ НЭХМЭЛ	75,240	25	ТАЛХ ЧИХЭР	161,663,500
НАКО ТҮЛШ	72,391	26	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	160,310,770
БАЯНГОЛ ЗБ	66,258	27	ГЕРМЕС ЦЕНТР	136,002,293
БУУДАЙН ЦАЦАЛ	58,037	28	БАГАНУУР	119,093,720
ГОВЬ	53,795	29	МАХИМПЕКС	114,251,196
ДАРХАН НЭХИЙ	50,624	30	ГУТАЛ	106,134,960
Нийт	51,123,848			22,882,295,397
Нийтэд эзлэх хувь	98.85			94.39

ИРГЭД, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Цэнхэр, ягаан тасалбар

Энэхүү хэсэг нь их хувьчлалын үеэр цэнхэр, ягаан тасалбар авсан иргэдэд зориулсан мэдээлэл агуулсан.

1990-ээд оны иргэдэд тараасан цэнхэр ягаан тасалбар нь одоог хүртэл олон иргэдийн анхаарлыг татсан асуудал хэвээр байгаа билээ. МХБ нь уг асуудлыг энэхүү жилийн тайландаа онцгойлон анхаарч тодорхой тайлбар, зөвлөгөө өгөхийг хичээлээ.

Юуны өмнө ард иргэд маань дараах хоёр зүйлийг илүү сонирхдог билээ. Эдгээр нь:

1. Цэнхэр ягаан тасалбар нь аль компанид орсон, одоог хүртэл ногдол ашиг аваагүй,
2. Үнэт цаасны дансаа шүүх, яагаад хэд хэдэн газар хандах шаардлага гардаг тухай юм.


Манай иргэдийн дунд 1990-ээд оны үед цэнхэр, ягаан тасалбараа авсан боловч хэдийд, ямар компанид хөрөнгө оруулсан тухайгаа мэдэхгүй, эсвэл мэддэг хэдий ч өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр хувьцаа нь зарагдсан гэх гомдол их гардаг. Эдгээр гомдолтой, саналтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг доорхи графикаас харна уу.

Та цэнхэр, ягаан тасалбар авч байсан уу?




Тавантолгойн 1072 хувьцаа

Манай иргэдийн хувьд Эрдэнэс Тавантолгойн гэх 1072 хувьцаатай холбоотой мэдээлэл лавлах нь элбэг байдаг. Иргэд өөрийн нэр дээрх хувьцааны тухай мэдээллийг Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд (ҮЦТТХТ) хандаж авах боломжтой юм. ҮЦТТХТ нь энэхүү хувьцаатай холбоотой анхан шатны, товч мэдээллийг өөрийн веб хуудсаараа дамжуулан өгөх боломжтой юм. Уг веб хаяг нь net.schcd.mn/registration юм. Энэ хаягаар орвол дараах хуудас нээгдэх болно.



Та "Регистр" гэсэн холбоос дээр дарахад өөрийн регистрийн дугаараа хийгээд хувьцаагаа шалгах боломжтой юм.

Үнэт цаасны дансны тухай мэдээлэл, Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Та Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн төв оффис дээр мөн авч болох юм. ҮЦТТХТ-ийн хаяг нь Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Самбуугийн гудамж 16/1 бөгөөд доорх газрын зургаас хэрхэн очих тухай мэдээллийг авна уу.




ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦАА ГАРГАХ АЖ АХУЙН НЭГЖИД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 1** Олон нийтэд үнэт цаасаа санал болгох шийдвэрээ гаргах
Үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гаргах /Хувьцаа эзэмшигчдийн хурал, үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөл гэх мэт/
- 2** Зөвлөхүүдээ томилж зөвлөгөө авах
Андеррайтерийн, аудитын, зэрэг зөвлөх компаниудыг сонгох эдгээр зөвлөхүүд нь хууль зүйн, санхүү бүртгэлийн олон асуудлаар танай компанид шинжилгээ хийж зөвлөгөө өгөх ба үнэт цаасны танилцуулга бэлтгэх, үнэт цаасны үнэ ханш тогтоох, үнэт цаасыг сурталчлан борлуулах зэргээр компанийн үнэт цаас гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг
- 3** Бэлтгэл үе Үнэт цаасны танилцуулга бэлтгэх
Урьдчилсан судалгаа хийх / due diligence / Үнэт цаас гаргагч компани болон гаргаж буй үнэт цаасны тухай мэдээлэл бүхий үнэт цаасны танилцуулга бэлтгэх
- 4** Бүртгүүлэх хүсэлтээ зэрэг өгч болно
“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон Санхүүгийн Зохицуулах Хороо /СЗХ/-ны “Бүртгэлийн журам”-ын дагуу СЗХ-нд хүсэлтээ хүргүүлж, үнэт цаас гаргах зөвшөөрөл авах дэлгэрэнгүйг www.frc.mn-ээс /
- 5** СЗХ-ноос зөвшөөрөл авах
МХБ-д бүртгүүлэх
Монголын Хөрөнгийн Бирж /МХБ/-ийн “Бүртгэлийн журам”-ын дагуу үнэт цаас бүртгүүлэх хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт МХБ-д ирүүлж, МХБ-ээс бүртгэлийн шалгалт хийж бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах
- 6** Үнэт цаасыг олон нийтэд сурталчлах, хуваарилах
СЗХ-ноос зөвшөөрсний дагуу олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээлэл цацах, сурталчилгаа, идэвхжүүлэлтийн ажил хийх. Хөрөнгө оруулагчдаас үнэт цаас худалдан авах захиалга авч үнэт цаасыг хуваарилна.
- 7** Үнэт цаасаа арилжих
Үнэт цаасыг анхдагч зах зээлийн арилжаанд оруулах тухай СЗХ-оос зөвшөөрснийг үндэслэн үнэт цаасны арилжааг зохион байгуулж явуулна.
- 8** Үнэт цаасны хоёрдогч зах зээл
Үнэт цаас анхдагч зах зээлд амжилттай арилжиж дууссаны үндсэн дээр СЗХ-ны зөвшөөрлөөр хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх ба ийнхүү танай компанийн үнэт цаас ажлын өдөр бүр Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын хооронд чөлөөтэй арилжаалагдах боломж бүрдэнэ.

МХБ-Д БҮРТГҮҮЛЭХ ҮЕ ШАТ



ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Хувьцаат компани нь өөрийн олон улсын хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж, МХБ-д бүртгэлтэй хэвээр байхын тулд “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журам, заавруудыг мөрдөх үүргийг хүлээнэ.

Үнэт цаасны бүртгэлийн шаардлага үргэлжлүүлэн хангах

Компани нь үнэт цаасаа бүртгүүлэхийн тулд үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангах ёстой бөгөөд бүртгэлтэй байх хугацаанд эдгээр шалгуур, шаардлагыг тогтмол хангах үүрэгтэй.

Мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэх

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнэ ханш, тоо хэмжээ, арилжааны идэвхид нөлөөлж болохуйц бүх мэдээ, мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагатай (СЗХ-ны “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн



сангийн журам”, “МХБ-ийн бүртгэлийн журам” болон “Бүртгэлтэй компаниуд цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-ыг харна уу)

Санхүүгийн тайлан, мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнах

Хагас жилийн болон аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайланг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д заасан хугацаанд гарган хүргүүлэх, тайлангийн хураангуйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх

Компанийн сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх

Хувьцаат компаниуд нь Монголын компанийн засаглалын кодекст-т нийцүүлэн дотоод дүрэм, журмаа боловсруулж үйл ажиллагаа явуулна.

Хувь нийлүүлэгчдийн хурал зарлан хуралдуулах

Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах ба хурлаас гарсан шийдвэр тэмдэглэлийг СЗХ болон МХБ-д ирүүлнэ.

Ногдол ашиг тараах эсэх

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргах ба ногдол ашиг хуваарилахаар шийдсэн тохиолдолд хугацаандаа хуваарилах, хуваарилахгүй тохиолдолд хугацаанд нь шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.



ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

		I ангилал	II ангилал	III ангилал
Үнэт цаасанд тавих шалгуур				
1	Зах зээлийн үнэ (төгрөгөөр)	10.0 тэрбумаас дээш	1.0 тэрбумаас дээш	Компанийн хүсэлтийг харгалзан МХБ-ээс тухай бүр тогтоосон шаардлагыг хангах
2	Олон нийтэд санал болгох хувь	25%-иас доошгүй	15%-иас доошгүй	-
3	Арилжигдсан хугацаа	2 жил	-	-
4	Үнэт цаас нь арилжигдах боломжтой байх	Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх		
Компанид тавих шалгуур				
5	Үйл ажиллагаа явуулсан жил	3-аас доошгүй	2-оос доошгүй	-
6	Санхүүгийн тайлан	3 жил IFRS/GAAP	2 жил IFRS/GAAP	-
7	Сүүлийн жилийн БО-ын хэмжээ (төг)	10.0 тэрбумаас дээш	-	-
8	Сүүлийн жилийн ашгийн хэмжээ (төг)	1.0 тэрбумаас дээш	-	-
9	Эргэлтийн хөрөнгө	-	Бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хэрэглэх хангалттай э/х-тэй байх	-
10	Андеррайтертэй байх	+	+	+
11	Компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх	+	+(үгүй бол тайлбар)	+(үгүй бол тайлбар)
12	Компани, ТУЗ, Хяналтын багц эзэмшигч, ГЗ-ын шалгуур	Татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх, хэрэв өртэй тохиолдолд өр зээлийн талаар үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй мэдээлсэн байх		
13	Удирдлагын багийн туршлага, түүний болон хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд орсон өөрчлөлт	Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай байх Сүүлийн 2 жилийн дотор компанийн ГЗ-д эсхүл удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд, Сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх,	-	-



КОМПАНИЙН БОНД ГАРГАХ АЖ АХУЙН НЭГЖИД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Компани урт хугацааны санхүүжилт авах шаардлага зайлшгүй тулгардаг бөгөөд энэхүү асуудлыг өрийн хэрэгслээр шийдвэрлэх нь үр ашигтай гэж үздэг байна. 2001 онд анх Монголын хөрөнгийн биржид компанийн бонд гарснаас хойш нийт 13 компани 18.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

2014 онд Монголын хөрөнгийн бирж “Бүртгэлийн журам”-даа шинэчлэл хийснээр компанийн бонд гаргах үйл ажиллагаа өмнөх үеэсээ харьцангуй хялбар болсон гэж ойлгож болно. Уг журмын дагуу үнэт цаас гаргагч нь өрийн бичиг гаргах хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-д зэрэг өгч болохоос гадна шийдвэр гаргах хугацаа нь 30 хоногоос 20 хүртэл хоног болж богиноссон байна. Мөн барьцаа хөрөнгө хангалтгүй бол олон улсын болон дотоодын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ буюу санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон, зэрэглэл өндөртэй байх шаардлагыг нэмж өгснөөрөө онцлогтой юм. Иймд барьцаа хөрөнгө нь хангалтгүй байгаа компаниуд үнэлгээний байгууллагуудаар зээлжих эрхийн үнэлгээ хийлгэснээр өрийн бичиг гаргах боломж бүрдэж байгаа юм.

Арилжаанаас банкнаас зээл авах болон хөрөнгийн зах зээл дээр өрийн бичиг гаргах байдлыг харьцуулах нь:

Үзүүлэлтүүд	МХБ-д өрийн бичиг гаргах	Арилжааны банкууд
Санхүүжилтийн хүү	Өөрсдөө шийднэ	≈ 20%
Санхүүжилтийн хугацаа	Өөрсдөө шийднэ	≈ 36 сар хүртэл
Санхүүжилтийн хэмжээ	Өөрийн хөрөнгөнөөс хэтрэхгүй байх	Бизнесийн цар хүрээнээс хамаараад 1 тэрбум төг хүртэл
Тавигдах шаардлага:		
Үйл ажиллагаа явуулсан жил	3 жилээс доошгүй	1 жилээс доошгүй
Барьцаа хөрөнгө (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө)	Барьцаа хөрөнгө шаардаж болно. Барьцаа хөрөнгө хангалтгүй тохиолдолд үнэлгээний байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ хийлгэсэн байх	Барьцаа хөрөнгө заавал шаардахаас барьцаа хөрөнгийн тодорхой хувиар зээл олгогдоно.
Зээлийн сайн түүхтэй байх	-	✓
Бусад банк болон санхүүгийн байгууллагад зээлийн өргүй байх	-	✓
Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх	-	✓

Компанийн бонд гаргах болон арилжааны банкнаас зээл авахад гарах зардлууд:

Хүлээн авагч байгууллага	Зардлын төрөл
Зохицуулах байгууллага	Тэмдэгтийн хураамж, бүртгэлийн хураамж (Нийт гаргаж буй хэмжээний 0.05-0.1%)
Хөрөнгийн бирж	Бүртгэлийн хураамж (Нийт гаргаж буй хэмжээний $\approx 0.1\%$)
Зуучлагч байгууллага	Андеррайтинг хийх хөлс, батлан даалтын хөлс гэх мэт (Нийт гаргаж буй хэмжээний 0.25-1.50%)
Мэргэжлийн байгууллагын хөлс	Хуулийн зөвлөгөө, үнэлгээний байгууллагын хөлс (Нийт гаргаж буй хэмжээний 0.02-0.0325%)
Бусад зардал	Сурталчилгаа, хэвлэлийн зардлууд гэх мэт


Компанийн бонд гаргахад тавигдах шалгуур:



Компанийн бонд гаргах хууль эрх зүйн боломжууд:

- ◆ Хувьцаат компани болон Хязгаарлагдмал хариуцлагатай компани аль аль нь компанийн бонд гаргах боломжтой.
- ◆ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны журмаар компанийн бонд гаргахад тавигдах шаардлага багассан. Үүнд: Бонд гаргахыг хүссэн компани нь андеррайтерийн, аудитын, хуулийн, хөрөнгийн үнэлгээний байгууллагуудтай хамтран үнэт цаасны танилцуулга бэлтгэсэн байх үндсэн шаардлага тавигдаж байна.
- ◆ ҮЦЗЗТХ, ХОС-ын хууль батлагдсанаар мэргэжлийн хөрөнгө оруулагчид үүсч бий болох нөхцөл бүрдсэн.
- ◆ Даатгалын сангийн хөрөнгийн 20 хүртэл хувийг компанийн бондод хөрөнгө оруулалт хийж болохоор туссан.
- ◆ Компанийн бонд гаргахад үнэт цаас гаргагч татвар төлөхгүй.

КОМПАНИЙН БОНД ГАРГАХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монголын улсын компанийн тухай хуульд зааснаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн хурал, түүний чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна.

